



**ӨВӨЛЖИЛТ, ХАВАРЖИЛТ ХҮНДРЭХ БОЛОН ЗУДЫН АЮУЛААС  
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ НЭГДСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ  
УДИРДАМЖ**

**Нэг. Зорилго**

1.1 Өвөлжилт, хаваржилтыг хохирол багатай даван туулах, цаг агаарын гаралтай аюулт болон гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээг ард иргэд, малчин айл өрхүүдэд зохион байгуулах, гамшгийн эрсдэлийг бууруулахад мэргэжлийн байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэхэд чиглэгдэнэ.

**Хоёр. Хугацаа, хамрах хүрээ**

2.1. I үе шатыг 2024 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс 05 дугаар сарын 01, II үе шатыг 08 дугаар сарын 01-ний өдрөөс 11 дүгээр сарын 21-ний өдрийн хооронд тус тус зохион байгуулна.

2.2. Аймаг, сум, нийслэл, дүүрэг, баг, хорооны иргэд, малчид бүх түвшинд аюулгүйн нөөц бүрдүүлэлт, түлш, эрчим хүчний байнгын хэвийн тогтвортой ажиллагааг хангах, малчин айл өрхийн өвөлжилт, хаваржилтын бэлтгэл бэлэн байдал, зам давааны нэвтрүүлэх чадамжийг хангахад чиглэгдэнэ.

**Гурав. Зохион байгуулалт**

3.1. Цаг уур, орчны шинжилгээний газраас гаргасан өвөлжилт, хаваржилт, ган, зудын эрсдэлийн үнэлгээнд үндэслэн хариу арга хэмжээний төлөвлөгөөг тодотгон аймаг, сумын Онцгой комисс боловсруулан хэрэгжүүлнэ.

3.2. Цаг агаарын богино, дунд, урт хугацааны мэдээ, зудын эрсдэлийн мэдээг орон нутгийн хэмжээнд нарийвчлан тодруулж, бүх төрлийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, "Багц мессеж"-ээр иргэд, малчид, аж ахуйн нэгж, байгууллагад шуурхай хүргэнэ.

3.3. Засгийн газрын тогтоолын дагуу аймаг, сумын өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг бэлтгэнэ.

3.4. Бэлчээрийн даацын судалгаанд үндэслэн малыг эдийн засгийн эргэлтэд оруулах, малчдад мал, мах, түүхий эдээ худалдан борлуулах ажилд дэмжлэг үзүүлэх арга хэмжээг зохион байгуулна.

3.5 Мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулж, зүй бусаар хорогдсон мал, амьтны сэг зэм устгал хийнэ.

3.6. Орон нутгийн авто зам, даваа хаагдах, хүндрэл үүссэн үед шаардагдах нөөц бүрдүүлэх ажлыг зохион байгуулна.

3.7. Төв, суурин газрын өвөлжилтийн бэлтгэл, бэлэн байдал, дулааны станц, уурын зуух, шугам сүлжээний засвар үйлчилгээ, аюулгүйн нөөц бүрдүүлэлт, түлш шатахууны тасалдалгүй байдлыг хангана.

3.8. Цаг агаарын аюулт үзэгдлийн үед ажиллах томилгоот бүрэлдэхүүн, техник хэрэгсэл, алба мэргэжлийн ангийн бэлтгэл бэлэн байдлыг хангуулна.

3.9. Онцгой байдлын ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх газар, Эрсдэлийн удирдлагын газраас удирдамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжлийн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллана.

Аймгийн нэр	Багц мессэж	Орсон цасны тоо	Үргэлжилсэн Хугацаа (цагаар)	Зам гарц гаргасан байдал		Цасан суусан дуудлага			Хүний тоо			Төөрсөн, сураггүй болсон дуудлага						
				Даваа	Айл руу	Тоо	Ажилласан хүн, хүч	Тээврийн хэрэгсэл	Эрэгтэй	Эмэгтэй	Хүүхэд	Тоо	Ажилласан хүн, хүч	Хүний тоо				
														Эрэгтэй	Эмэгтэй	Хүүхэд		

**Дөрөв. Нэгдсэн арга хэмжээний үр дүн, зардал**

4.1. Төв, орон нутгийн хэмжээнд зохион байгуулсан арга хэмжээний I үе шатны тайланг 2024 оны 05 дугаар сарын 5, II үе шатны тайланг 11 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Онцгой байдлын ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх газарт [uugankhuu@nema.gov.mn](mailto:uugankhuu@nema.gov.mn) цахим хаягаар баталгаажсан тайлан, шалгуур үзүүлэлтийн хүснэгтийн хамт сканердан (файлаар, зурган тайлан) ирүүлнэ.

4.2. Улсын хэмжээнд зохион байгуулсан нэгдсэн арга хэмжээний тайланг Урьдчилан сэргийлэх газар нэгтгэн, Онцгой байдлын ерөнхий газрын даргад 2024 оны 05 дугаар сарын 13, 12 дугаар сарын 05-ны өдрийн дотор танилцуулж, тайлангийн хувийг Монгол Улсын Шадар сайдын ажлын албанд хүргүүлнэ.

4.3. Нэгдсэн арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах зардлыг Гамшгаас хамгаалах тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.1, 31.1.3-т заасны дагуу шийдвэрлүүлэх, түүнчлэн Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн үйл ажиллагааны зардал болон төсөл хөтөлбөр, олон улсын байгууллагаас санхүүжүүлнэ.